

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2021 оны 6 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	<u>Сумдын эмнэлэг</u>	<u>Өрхийн эмнэлэг</u>	<u>Хувийн эмнэлэг</u>	<u>Цэргийн анги</u>	<u>Нийт дүн</u>
1	Нийт үзлэг	35266	72641	48311	23062	3462	180742
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	11468	35822	25817	3556	3224	79887
3	Идэвхтэй хяналтын үзлэг	4429	13074	9860	2348		29711
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	12396	10651	3485	5798	201	32531
5	Нийт төрөлт	684	191				875
6	Хэвтэн эмчлүүлэгчид	3229	1926		1766	27	6948
7	Нас баралт	12	85	44			141

№	Үзүүлэлт	<u>2020.6</u>	<u>2021.6</u>	<u>Өөрчлөлт</u>
1	Нийт үзлэг	180384	180742	358
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	59018	79887	20869
3	Идэвхтэй хяналтын үзлэг	7913	2348	-5565
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	42365	32531	-9834
5	Нийт төрөлт	822	875	53
Үүнээс	Гэрийн төрөлт	4	4	0
	Охидын төрөлт	59	50	-9
	Охидын төрөлтийн эзлэх хувь	7,1	5,7	-1.4
6	Хэвтэн эмчлүүлэгчид	8066	6948	-1118
7	Нас баралт	141	141	0
	0-1 насны эндэгдэл	9	7	-2
	1-5 насны эндэгдэл	2	1	-1
	Хурц халдварт өвчин	107	20	-87

Үзүүлэлт	хэмжих нэгж	2010.6 сар	2021.6 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	10.9	7.9	-3
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	373.4	342.7	-30.7
Үүнээс охидын	хувь	8.4	10.5	2.1
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	15.3	2.8	-12.5
БЗДХ	10000 хүн амд	28.4	9.3	-19.1
Үүнээс өсвөр үе	хувь	10.5 /21/	11.9/8/	1.4
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	67.2	77.8	10.6
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	37.3	48.1	10.8

I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 180742 хүнд үзлэг шинжилгээ хийсний 45.4%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 6948 хүнийг 43774 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.3 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 4706 дуудлагад явж үйлчилсний 778/16.5%/ нь алсын дуудлага, 333/7%/нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 74.2% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна.
- Нийт эмийн сангууд 37049 жор хүлээн авч 5 тэрбум 800 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 7713 жор ирсний 54,4% /4203/ нь ЭМДаатгалын, 3,3%/259/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 42,1% /3250/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 76,5% байна.

II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

- 6 сарын байдлаар 32531 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9834 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 62.6% нь шинэ өвчлөл байна.
- Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:**

1. **Хоол шингээх эрхтний өвчин-8709**, /49,8% шүдний цоорол, 16,6% ходоодны, 7,3% элэгний үрэвсэл/
2. Амьсгалын тогтолцооны өвчин-4331
3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-4208 /Артерийн даралт ихдэх 54.4%, зүрхний ишемит өвчин 16.5%
4. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-3632
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-2926

- 6 сарын байдлаар 747 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 17 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 1-р буурч, өвчлөл 54 тохиолдлоор өссөн байна.
- Осол гэмтлээр нас барагсдын 17,6%/3/нь амиа хорлосон-/Мн-1,Цц-1,Эх-1/,47% /8/нь зам тээврийн осол-/Бд-1,Гт-1,Нн-1,Хх-1, Цц-2,Боэт-1,Өо-1/, 35,2% /6/ нь бусад ослоор /Бо-2,Хү-1,Цц-2,БОЭТ-1/ тус тус эндсэн байна.
- Осол гэмтлээр нас барагсад нь 86,6% /14/ эрэгтэй ба 3 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч 2 нь хоног болоогүй нас барсан байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 141 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 12% нь осол гэмтлээр, 23,4% нь хорт хавдраар, **7,8%** нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 2.1% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна. Нийт нас баралтын 22/15.6%/ нь эмнэлэгт, бусад нь гэртээ, хээр гадаа нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 7 /Бо-1,Гт-1,Мо-1,Но-1,БОЭТ-3/ тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 7.9% байна.
- Нялхсын эндэгдэл 2020 онд 44.4% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2021 онд 42.8% нь эрт нярайн, 57.1% нь сараас дээш насны хүүхэд 2 байгаа ба 1 нь хатгаагаар, 1 нь осол гэмтлээр эндсэн байна
- БОЭТөвд 12 эндэгдэл тохиолдож задлан шинжилгээ 80% тай байна. Үндсэн оношийн зөрөө байхгүй.
- Нас баралтын шалтгаан:**

1. **Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-62**
2. Хорт хавдарын нас баралт-33
3. Бэртэл хордлого гадны шалтгаант нас баралт-17
4. Хоол шингээх эрхтний өвчин-13
5. Төрөх, перинаталь үед үүсэх эмгэг-3/ нярай/
6. Уушигны хатгаа 3
7. Бөөрний эмгэг 5
8. Үжил-1
9. Уушигны бөглөрөлттэй-1
10. Мэдрэлийн өвчин-1
11. Ковид 19-1

III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 875 эх төрж 881 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 53 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 5,7%/ 50/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бо-2,Бу-1,Гт-1,Мн-2,Нн-1,Сэ-2,Хб-8,Хх-2,Хү-1,Цо-1,Цц-2,Шб-10,Өо-6,Эх-8,Бг-3/.
- 6 сарын байдлаар 302 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 342,9 байгаа нь өнгөрсөн оноос **30,7-р** буурсан үзүүлэлт байна. Өсвөр насны охидын үр хөндөлт-32/10,5%/Бд-3,Бу-2,Гт-2,Мн-2,Но-1,Нн-1,Хб-1,Хх-1,Цо-2,Цц-3,Шб-4,Өо-5, Эх-2,Бг-3/ байна.
- Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 30,7-р буурч, охидын үр хөндөлт 2,1-р нэмэгдсэн байна.
- 6 сарын байдлаар сард дундажаар 5533 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 54,1% эзэлж байгаа нь өнгөрсөн оноос нэмэгдсэн хэдий ч хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 14 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,7%-г эзэлж байгаа ба 20 хүүхэд туранхай, 13 хүүхэд өсөлтийн хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 10,6-р, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 10,8-р тус тус нэмэгдсэн байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 202 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 120 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 1,9%-г салхинцэцэг, 3,4% сүрьеэ, 2,9%-г гар хөл амны өвчин, 3,4% цусан суулга, 86,6%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 26,8% нь жирэмсний үзлэгээс, 19,4% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 28,3% нь өвчний учир амбулатороор, 25,3% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

ДЭЭРХ ҮЗҮҮЛЭЛТЭЭС ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Охидын үр хөндөлт, БЗДХ өмнөх жилээс нэмэгдэх хандлагатай байгаад анхаарч өсвөр үеийн эрүүл мэнд, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг сайжруулахад илүү үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай.
2. Гэрийн 4 төрөлт нь алслагдсан хөдөө орон нутагт биш, аймгийн төв дээр тохиолдсон байгаа нь хөдөө орон нутгаас ирсэн эхчүүдийн хяналт, төрөх дөхсөн эхчүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
3. БЗДХ-н 54 % нь идэвхгүй үзлэг тандалтаар илэрсэн байгаа нь хүн амын дундах өвчлөлийн тархалт байгааг харуулж байгаа ба урьдчилан сэргийлэх үзлэг, илрүүлэлтийг идэвхжүүлэх шаардлагатай.
4. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон хоол боловсруулах эрхтэний болон зүрх судасны эмгэгийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, мэдээлэл сургалт сурталчилгаа, эрт илрүүлэг хяналт эмчилгээг сайжруулах
5. Осол гэмтлийн өвчлөл өнгөрсөн оноос нэмэгдсэн байгаа ба өвчлөлийн 24,6%, нас баралтын 46,6% зам тээврийн осол байна. Мөн осол гэмтлийн өвчлөлийн 55,8% нь гадны шалтгаан, орчин нөхцөл, ажлын байрны аюулгүй ажиллагаатай, 13,5% хүчирхийллийн шалтгаантай байгаад анхаарч осол гэмтлийн өвчлөл нас баралтыг бууруулахад салбан дундын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.
6. Нас баралтын голлох шалтгаан нь цусны эргэлтийн тогтолцооны эмгэг буюу тархинд цус харвалт, зүрхний ишемит эмгэг зэрэг сэргийлж болох эндэгдэл тэргүүлж байгаа ба эрт илрүүлэлт, хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б. Мидэрсүрэн , Д. Гантогтох

0,8% /55/ нь алдаатай жор байсан байна.